



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН,
452.8 САЯ ТӨГРӨГИЙН 2 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ГЭРЭЭНИЙ
ХУГАЦААНД БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
АУДИТЫН КОД: УВА-2025/06-19/-ШТА-НА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453317 Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор А.Нанжидмаа

Утас: 70453317 Цахим хаяг: nanjidmaaa@audit.gov.mn

Аудитор Т.Золоо

Утас: 70453317 Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

Аудитор Л.Шагдарсүрэн

Утас: 70453317 Цахим хаяг: shagdarsurenl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Open. audit.mn хаягаар авна уу.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	4
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	5
Аудитын менежер М.Бат-Амгалан	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	
Аудитор Т.Золоо А.Нанжидмаа Л.Шагдарсүрэн	БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа ч хууль, журамд заасан зарим шаардлага хангаагүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	8
	<i>1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй 1 төсөл, арга хэмжээ баталсан байна.</i>	10
	<i>1.2. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.</i>	
	БҮЛЭГ 2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна	11
2025 оны 5 дугаар сар	<i>2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.</i>	11
	<i>2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан ч, 27 төсөл, арга хэмжээний тендерийн сонгон шалгаруулалтыг төлөвлөгөөт хугацаанаас 6-187 хоноогоор хэтрүүлэн зарласан байна.</i>	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	<i>2.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 1 гомдол гаргасан байна.</i>	16
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	БҮЛЭГ 3. Төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлсэн ч, 425.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	18
	<i>3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжилтийг олгосон байна.</i>	18
	<i>3.2 Төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй 6 төсөл, арга хэмжээ байна.</i>	19
	<i>3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн хугацаанд холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлсэн байна.</i>	20
	<i>3.4 Хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээний 425.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.</i>	21
	ДҮГНЭЛТ	22

	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	23
	АУДИТЫН ГАЗРААС ӨГӨХ ТАЙЛБАР	
	ЗӨВЛӨМЖ	27 28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УВА	УВС АЙМАГ
ШТА	ШУУД ТАЙЛАГНАХ АУДИТ
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ОНХО	ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТАХ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
УТХО	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ХА	ХАРЬЦУУЛАЛТЫН АРГА
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ГИХГ	ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТӨХК	ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ШХА	ШУУД ХУДАЛДАН АВАЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд уялдсан байдал.....	8
Хүснэгт 2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ	11
Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан төсөл, арга хэмжээ...	12
Хүснэгт 4. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ.....	13
Хүснэгт 5. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ	16
Хүснэгт 6. Шаардлага хангасан оролцогч оролцоогүй 2 төсөл, арга хэмжээ	16
Хүснэгт 7. Гүйцэтгэл дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ	17
Хүснэгт 8. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавр хийгдсэн төсөл, арга хэмжээ	20

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх.
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 36, замын сангийн хөрөнгө оруулалтын 10, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2, нийт 48 төсөл, арга хэмжээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтийг хамруулан хийлээ.

Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд санхүүжүүлэхээр баталсан 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулсан.

Арга зүй

АДБОУС 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан,

тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт, судалгаа хийх арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, А.Нанжидмаа, Л.Шагдарсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг анх аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор баталж, 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,228.4 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 60.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 1,767.7 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ, нийт 7,056.6 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 1 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”, 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 7,036.5 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ уялдаж, харин 20.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ уялдаагүй байна.

Хүснэгт 1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд уялдсан байдал:

Д/д	Бодлогын баримт бичиг	Бүлгийн агуулга	ТАХ-ийн тоо
1	Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Хүний хөгжлийн бодлого	11
		Эдийн засгийн бодлого	1
		Засаглалын бодлого	7
		Ногоон хөгжлийн бодлого	2
		Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого	26
2	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 8 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	3
		Хүний хөгжил	9
		Амьдралын чанар ба дундаж давхарга	2
		Эдийн засаг	
		Засаглал	
		Ногоон хөгжил	2
		Амар тайван, аюулгүй нийгэм	5
Бүс, сум, орон нутгийн хөгжил	26		

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй “Алтан үе ахмадын сувилал”-ын ажлын барьцаа 5 хувь болох 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байхыг зөвлөмж болгов.

1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.

Аймгийн Засаг дарга нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүргүүлэхдээ байгууллага, сумдын саналыг авч аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан эрэмбэлж төлөвлөсөн байна. Үүнд; Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/1958 дугаар албан бичгээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3,801.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,573.3 сая төгрөгийн 7, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 60.5 сая төгрөгийн 2, нийт 5,435.0 сая төгрөгийн 39 төсөл, арга хэмжээний саналыг аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/04 дүгээр тогтоолоор 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,852.3 сая төгрөгийн 34, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,753.3 сая төгрөгийн 9, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 60.5 сая төгрөгийн 2, нийт 6,666.1 сая төгрөгийн 45 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 21/01 дүгээр тогтоолоор аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5,228.3 сая төгрөгийн 36, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,767.7 сая төгрөгийн 10, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 60.5 сая төгрөгийн 2, нийт 7,056.5 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээг баталсан байна. Энэ нь анх баталсан төсөл, арга хэмжээнээс 40.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хасаж, 509.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

- Түргэн сумын Ойн ангийн гүний худаг бүхий цахилгаан шугам татах 30.0 сая
- Хөв цөөрөм байгуулах зураг төсөв /17 сумын 27 байршлаас сонгох/ 10.5 сая

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

- Увс аймгийн аялал жуулчлалын лавлах хэвлэх 16.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Улаангом сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээ 54.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Улаангом сумын гэр хорооллын хогны автомашин худалдан авах 82.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ

- Улаангом сумын Соёлын төвийн орон нутгийн Музейн тохижилт 6.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Улаангом сумын “Ногоон бүс” камержуулалт 350.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ

Төсвийн тухай хуулийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасны дагуу 47 төсөл, арга хэмжээ нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, ажлын даалгавар, техникийн тодорхойлолттой байна.

Төсвийн тухай хуулийн 29¹.2.2 дахь заалт “Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх” гэж заасны дагуу Улаангом сумын 5-р багийн хатуу хучилттай авто зам /Эрдмийн эхлэл сургуулийн урд засмал замыг үргэлжлүүлэх/ төсөл, арга хэмжээ нь 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 236/2024 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Харин Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтад Шүүхийн шийдвэрийн дагуу “Алтан үе ахмадын сувилал”-ын ажлын барьцаа 5 хувь /Түргэн сум, Цүнхэг амралт/ 20.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ баталсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.1-д “Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна”, 2.2-д “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж заасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр баталсан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 31, замын сангийн хөрөнгө оруулалтаар 7, нийт 38 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2024 оны 05 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах

ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ” гэж заасны дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 48 төсөл, арга хэмжээнээс 18 төсөл, арга хэмжээний эрхийг тайлант онд харьяалах төсвийн захирагч нарт шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсэн 18 төсөл, арга хэмжээнээс 7 төсөл, арга хэмжээний эрхийг хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Цаашид хуулийн хугацаанд төсөл, арга хэмжээний эрх шилжүүлж байхыг зөвлөлөө.

Хүснэгт 2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Захирамжийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр
1	Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын барилгын хэсэгчилсэн засвар Сургуулийн хуучин спорт заалыг сурагчдын хоолны газар, урлаг заал болгон засварлах /Сагил сум/ Сургуулийн урд талбайн тохижилт засвар /Сагил сум/ Наадмын талбайн засвар шинэчлэл /Бөхмөрөн сум/ Наадмын талбайн засвар шинэчлэл /Өмнөговь сум/ Наадмын талбайн засвар шинэчлэл /Малчин сум/ Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн хилийн хяналтын тоног төхөөрөмж /Баруунтуруун сум/ 6 айлын 1 орон сууцны барилгын материал /Давст, Боршоо боомт/ Наадмын талбайн шинэчлэл /Тэс сум/ Наадмын талбайн шинэчлэл /Зүүнхангай сум/ Зэвсэгт хүчний 328 дугаар ангийн холбооны тоног төхөөрөмж /Зүүнговь сум/
2	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/103 дугаар захирамж	<ul style="list-style-type: none"> Шивэрийн голын зам засвар /Ховд сум/ Намирын голын гүүрнээс Холбооны багийн төв чиглэлийн 5 км хайрган замын засвар /Өмнөговь сум/
3	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/122 дугаар захирамж	<ul style="list-style-type: none"> Мал эмнэлгийн газрын хуучин вакцин, биобэлдмэлийн хөргүүрийг нүүлгэх, засварлах Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа хийх
4	Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/441 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> Улаангом сум доторх хатуу хучилттай авто замын засвар /Улаангом сум/
5	Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/559 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> Соёлын төвийн орон нутгийн музейн тохижилт /Улаангом сум/ Увс аймгийн аялал жуулчлалын лавлах хэвлэх

сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 48 төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан 39, шууд гэрээ байгуулсан 7, өмнөх оноос шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээ байна.

Цахимаар зохион байгуулсан 39 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээг аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авалтын арга	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан дүн
1	Цэцэрлэгийн барилгын засвар, шинэчлэлийн үргэлжлэл /Увс, Улаангом сум, 9-р цэцэрлэг/	НТШ	246.5	246.5
2	Дотуур байрны барилгын засвар, шинэчлэл /Завхан сум/	НТШ	451.3	451.3
3	Дотуур байрны барилгын засвар, тохижилтын ажлыг эхлүүлэх /Тэс сум/	НТШ	1,015.4	357.0
4	Сургуулийн дотуур байрны хэсэгчилсэн засвар /Өлгий сум/	ХА	149.7	149.7
5	Маршал Ю.Цэдэнбалын нэрэмжит Музейн барилгын хэсэгчилсэн засвар /Улаангом сум/	НТШ	514.7	162.0
6	600-р байрны 8 айлын орон сууцны барилгын гадна фасад дээврийн засварын ажил /Улаангом сум/	НТШ	184.9	184.9
7	Онцгой байдлын газрын ажилчдын 8 айлын орон сууцны барилгын гадна фасад, дээврийн засварын ажил /Улаангом сум/	НТШ	158.0	158.0
8	ЗДТГ-ын байрны засвар, шинэчлэл /Хяргас сум/	ХА	78.7	78.7
9	Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр /Улаангом сум/	ХА	60.0	-
10	Улаангом болон Боршоо боомт дахь ГИХГ-ын албан ерөө, автомашины иж бүрэн засвар /Улаангом сум/	ХА	29.0	29.0
11	Сумын төвийн тохижилт, ногоон байгууламж /Өндөрхангай сум/	ХА	49.6	49.6
12	Нийтийн эзэмшлийн ариун цэврийн байгууламжийн суурь, гадна холболтын зардал /Улаангом сум/	ХА	30.0	30.0
13	Цагдаагийн кабоны засвар, шинэчлэл /Тэс сум/	ХА	50.0	50.0
14	Гэр хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөлийн зураг төсөв /Тариалан сум/	ХА	29.1	29.1
15	ЕБ-ийн цогцолбор 2-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт /Улаангом сум/	НТШ	245.8	245.8
16	Соёлын төвийн засвар /Баруунтуруун сум/	ХА	110.0	110.0
17	Гудамжны гэрэлтүүлгийн ажил /Улаангом сум, 4-р баг/	НТШ	219.9	219.9
18	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Улаангом сум, 6-р баг/	ХА	130.9	130.9
19	Сумын төвийн гэрэлтүүлэг /Давст сум/	ХА	63.4	63.4
20	Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах /Улаангом сум/	ХА	60.0	59.9
21	Гэр хорооллын хогны автомашин худалдан авах /Улаангом тохижилт үйлчилгээний газар ОНӨГ/	ХА	82.3	78.1
22	"Ногоон бүс" камержуулалт /Улаангом сум/	ХА	350.0	329.3
		ХА		19.0
23	Улаангом сумын 5-р багийн хатуу хучилттай авто зам /Улаангом сум 5-р баг, Эрдмийн эхлэл сургуулийн урд засмал замыг үргэлжлүүлэх/	ХА	542.0	542.0
24	Аймгийн Цагдаагийн газрын гадна авто зогсоол /Улаангом/	ХА	339.3	339.3
25	Улаангом сумын 5-р багийн авто зам /Улаангом сум 5-р баг, "Ногоон төгөл" цэцэрлэгт хүрээлэнгийн уулзвараас Улаан уул чиглэлд/ зураг төсөв шинэчлэх	ХА	50.0	49.9
26	Авто тээврийн төвд Пүү авах	ХА	66.0	66.0
27	Авто замын тэмдэг, тэмдэглэгээ /Улаангом сум/	ХА	54.1	-

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан нийт 5,360.6 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээнээс 3,036.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалт, 2,324.1 сая төгрөгийн

төсөвт өртөгтэй 19 худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулсан байна.

Харин “Алтан үе ахмадын сувилал”-ын барилга угсралтын ажлын барьцаа 5 хувь буюу 20.0 сая төгрөгийг Увс аймаг дахь Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн магадлалын дагуу “Гончиг сум” ХХК-д шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн 18 төсөл, арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан бөгөөд 1 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт, 11 төсөл, арга хэмжээнд харьцуулалтын арга ашигласан байна. Харин 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй 3, хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник худалдан авах 3, нийт 6 төсөл, арга хэмжээнд шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 4. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ /Эрх шилжсэн ажил/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авалтын арга	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан дүн
1	Аймгийн боловсрол шинжлэх ухааны газрын барилгын хэсэгчилсэн засвар /Улаангом сум/	ХА	36.2	36.2
2	Сургуулийн хуучин спорт заалыг сурагчдын хоолны газар, урлаг заал болгон засварлах /Сагил сум/	ХА	27.2	27.2
3	Сургуулийн урд талбайн тохижилт, засвар /Сагил сум/	ХА	36.0	36.0
4	Наадмын талбайн засвар, шинэчлэл /Бөхмөрөн сум/	ХА	97.0	97.0
5	Наадмын талбайн засвар, шинэчлэл /Өмнөговь сум/	ХА	125.0	125.0
6	Наадмын талбайн, тоног төхөөрөмж, бараа худалдан авах /Малчин сум/.	ХА	100.0	91.3
7	Наадмын талбайг барихад дэмжлэг /Зүүнхангай сум/	ХА	149.5	149.5
8	Улаангом сум доторх хатуу хучилттай авто замын засвар /Улаангом сум/	ХА	50.0	50.0
9	Шивэрийн голын зам засвар /Ховд сум/	ХА	99.8	99.7
10	Намирын голын гүүрнээс Холбоо багийн төв чиглэлийн 5км хайрган замын засвар /Өмнөговь сум/	ХА	99.9	99.9
11	Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа хийх	ХА	43.7	43.7
12	Наадмын талбайн засвар, шинэчлэл /Тэс сум/	НТШ	199.9	199.9
13	Зэвсэгт хүчний 328-р ангийн холбооны тоног төхөөрөмж /Зүүнговь сум/	ШХА	6.1	6.1
14	Мал эмнэлгийн газрын хуучин вакцин, биобэлдмэлийн хөргүүрийг нүүлгэх, засварлах /Улаангом сум/	ШХА	10.0	10.0
15	Хилийн цэргийн 0311-р ангийн хилийн хяналтын тоног төхөөрөмж /Баруунтуруун сум/	ШХА	35.9	35.9
16	6 айлын 1 орон сууц барилгын материал /Давст, Боршоо боомт/	ШХА	70.0	70.0
17	Соёлын төвийн орон нутгийн музейн тохижилт /Улаангом сум/	ШХА	6.0	6.0
18	Увс аймгийн аялал жуулчлалын лавлах хэвлэх	ШХА	16.9	16.9

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх судалгаанаас харахад Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-т заасан төсөвт өртөгт нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан ч, 27 төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтыг төлөвлөгөөт хугацаанаас 6-187 хоногоор хэтрүүлэн зарласан байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд 25 үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулсан байна.

Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан гишүүдийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээг <https://new.tender.gov.mn/mn/exam/certificate> цахим системээс шалгахад 3 тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажилласан 2 гишүүний худалдан авах ажиллагааны гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, 1 гишүүн худалдан авах ажиллагааны гэрчилгээгүй байхад үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан байна.

Цаашид үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны мэргэшсэн эрхийн гэрчилгээ нь хүчинтэй байгаа иргэнийг ажиллуулахыг зөвлөв.

Төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд гаргасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”, 11.2 дахь хэсэгт “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

Худалдан авах ажиллагааны газраас 2024 онд зарласан 27 төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтыг төлөвлөгөөт хугацаанаас 6-187 хоногоор хэтрүүлэн зарласан байна.

Мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ” гэж заасны дагуу 25 худалдан авах ажиллагааны гэрээг захиалагчаас гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6-аас доошгүй буюу тогтоосон хугацаанд багтаан тендерт шалгарсан оролцогчидтой байгуулсан байна. Харин 2 худалдан авах ажиллагааны гэрээг тендерт шалгарсан

оролцогч захиалагчаас тогтоосон хугацаанаас ажлын 8-16 хоног хэтрүүлэн гэрээг баталгаажуулсан байна.

Эрх шилжсэн 18 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл, арга хэмжээнд захиалагчаас гэрээ байгуулах эрх олгосноос хойш тендерт шалгарсан оролцогчид тогтоосон хугацаанд багтаан гэрээ байгуулсан байна. Харин 3 худалдан авах ажиллагааны гэрээг тендерт шалгарсан оролцогч захиалагчаас тогтоосон хугацаанаас ажлын 3-9 хоног хэтрүүлэн гэрээг баталгаажуулсан байна.

Цаашид хуульд заасан хугацааг мөрдөж ажиллахыг зөвлөлөө.

2.3 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 1 гомдол гаргасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны газраас 27, эрх шилжсэн 12, нийт 39 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын зарлалыг <https://user.tender.gov.mn/mn/invitation> цахим системд бүрэн нийтэлж тендер оролцогчдыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Тендер оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу харьцуулалтын аргаар зарлагдсан 1 тендер оролцогч Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яам хянан үзэж гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгож, тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх мэдэгдэл хүргүүлжээ.

Хүснэгт 5. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гомдол гаргасан оролцогчийн нэр	Сангийн яамны шийдвэрлэлт	Эцсийн шийдвэрлэлт
1	Гэр хорооллын хогны автомашин худалдан авах/Улаангом тохижилт үйлчилгээний газар ОНӨГ/	“Монтех дистрибьюшн” ХХК	Дахин үнэлгээ хийх	Сангийн яаманд ирсэн гомдлын дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийж үнэлгээний хорооны гишүүд саналаа хэвээр үлдээсэн.

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Сангийн яамнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу үнэлгээний хороо хуралдан дахин үнэлгээ хийсэн ч тендерийн хорооны гишүүд өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Сангийн яаманд гомдол гаргасан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалт хийх талаар нэгтгэл тайланд тусгаж холбогдох яам, агентлагт уламжлуулах саналыг хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу Худалдан авах ажиллагааны газар тайлагнасан байна.

Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.4-д “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны тайланг цахим системд байршуулсан байна.

Худалдан авах ажиллагааны газраас 2 төсөл, арга хэмжээнд 2-7 удаа харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч шаардлага хангасан оролцогч оролцоогүй тул төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт 6. Шаардлага хангасан оролцогч оролцоогүй 2 төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Шалтгаан
1	Тэс авто замын боомтод Гадаадын иргэн харьяатын газрын албан хаагчийн амьдрах байр /Улаангом сум/	60.0	Худалдан авах ажиллагааг 7 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.
2	Авто замын тэмдэг, тэмдэглэгээ /Улаангом сум/	54.1	Худалдан авах ажиллагааг 2 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Тэс авто замын боомтод Гадаадын иргэн харьяатын газрын албан хаагчийн амьдрах байр /Улаангом сум/-ын тендер сонгон шалгаруулалтыг 7 удаа зарласнаас эхний 6 удаагийн сонгон шалгаруулалтад оролцогч оролцоогүй, сүүлийн сонгон шалгаруулалтад оролцсон оролцогч ерөнхий шалгуур хангаагүй байна. Мөн авто замын тэмдэг, тэмдэглэгээ /Улаангом сум/-ын тендер сонгон шалгаруулалтыг 2 удаа зарласан ч шалгуур шаардлага хангасан оролцогч ороогүй байна.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ОЛГОСОН Ч, 425.5 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГИЙГ ДАНС БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, гэж заажээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 48 төсөл, арга хэмжээнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 2, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 7, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 33, нийт 42 төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авч санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

Үлдсэн 6 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 4 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. Үүнд:

Хүснэгт 7. Гүйцэтгэл дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ

№	Аймаг, сумын нэр	Төсөл арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн	Гэрээний дүн	2025 онд зарцуулаагүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн /сая төг/
1	Сагил	Сургуулийн урд талбайн тохижилт, засвар /Сагил сум/	36.0	36.0	36.0
2	Улаангом	Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр /Улаангом сум/	60.0	0.0	60.0
3	Улаангом	“Ногоон бүс” камержуулалт /Улаангом сум/	331.0	329.3	329.3
4	Улаангом	Улаангом сумын 5-р багийн авто зам /Улаангом сум 5-р баг, "Ногоон төгөл" цэцэрлэгт хүрээлэнгийн уулзвараас Улаан уул чиглэлд/ зураг төсөв шинэчлэх	50.0	49.9	49.9
5	Улаангом	Хатуу хучилттай авто зам, тохижилтын ажил /Улаангом 5-р баг /	222.3	416.8	222.3

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх судалгаанаас харахад гэрээ байгуулсан ч ажил нь хийгдэж дуусаагүй, санхүүжилт олгоогүй 4 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 637.5 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/831 дүгээр захирамжийг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Харин Авто замын тэмдэг, тэмдэглэгээ /Улаангом сум/ 54.1 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Барьцаа хөрөнгийн дансанд байршуулах тухай” А/831 дүгээр захирамжаар их засвар хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сан, замын сангаас санхүүжигдэх төсөл, арга хэмжээний **үлдэгдэл** санхүүжилтийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Гэтэл “Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр” төсөл, арга хэмжээ нь гэрээ байгуулагдаагүй ажлын 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулахгүй байхыг зөвлөмж болголоо.

3.2 Төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй 6 төсөл, арга хэмжээ байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 48 төсөл, арга хэмжээнээс 42 төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон батлагдсан зураг төсөл, захиалагчтай байгуулсан гэрээний дагуу үе шатны ажил дээр хяналт хийж баталгаажуулан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын хавсралтаар баталсан “Гэрээ дүгнэх маягт”-ын дагуу гэрээг дүгнэн хүлээн авсан байна.

Харин 6 төсөл, арга хэмжээний хувьд 2 төсөл, арга хэмжээ нь огт хэрэгжээгүйгээс, 4 төсөл, арга хэмжээний хувьд дараах хүчин зүйлсээс шалтгаалан гэрээг дүгнээгүй байна.

Огт хэрэгжээгүй 2 төсөл, арга хэмжээ;

- Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр /Улаангом сум/ 60.0 сая төгрөг
- Авто замын тэмдэг, тэмдэглэгээ /Улаангом сум/-54.1 сая төгрөг

Дутуу хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ;

- “Ногоон бүс” камержуулатын /Улаангом сум/- төсөл, арга хэмжээний хувьд: 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд зарим тоног төхөөрөмж хил гаалийн асуудлаас болж ирээгүйгээс гэрээт хугацаанд ажлаа хийж гүйцэтгээгүй, Улсын комисс 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авч санхүүжилт олгосон байна.
- Улаангом сум 5-р баг “Ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнгийн уулзвараас Улаан уул чиглэлд/ зураг төсөв шинэчлэх- төсөл, арга хэмжээний хувьд: 2024 оны 12 дугаар сарын

05-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр комисс хүлээн авч санхүүжилт олгосон байна.

- Сургуулийн урд талбайн тохижилт, засвар /Сагил сум/-36.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хувьд: Тендер худалдан авах ажиллагаанд шалгуур хангасан оролцогч оролцоогүй тул тендер сонгон шалгаруулалтыг 7 удаа зарлаж цаг хугацаа алдсанаас шалтгаалан 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан ч ажил нь хийгдээгүй байна.
- Хатуу хучилттай авто зам, тохижилтын ажил /Улаангом 5-р баг/-416.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хувьд: 2023 онд гэрээ байгуулан хийгдэж 47 хувийн гүйцэтгэлтэй 194.4 сая төгрөгийн санхүүжилт авч, тайлант онд ажил нь хийгдсэн ч улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүйгээс хүлээж аваагүй, 2024 онд санхүүжилт олгоогүй байна.

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 2 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэхийг зөвлөмж болгов.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн хугацаанд холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1-д “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд улсын комисс ажиллуулах Засаг даргын захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Хүснэгт 8. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төг/	Төсөвт өртөг /сая төг/	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Зураг төсөл зохиогч байгууллагын нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн огноо
1	Цэцэрлэгийн барилгын засвар, шинэчлэлийн үргэлжлэл /Увс, Улаангом сум, 9-р цэцэрлэг/	246.51	246.51	"Энхдормон" ХХК	"Барилгын инженерүүд" ХХК	2024.06.24 №06/23
2	Дотуур байрны барилгын засвар, шинэчлэл /Завхан сум/	451.38	451.38	"Гурван тэрмис" ХХК	"Барилгын инженерүүд" ХХК	2024.10.22 №29
3	Дотуур байрны барилгын засвар, тохижилтын ажлыг эхлүүлэх /Тэс сум/	1,015.40	357.00	"Мөнхийн Ундраа" Увс ХХК	Барокко хийц ХХК	2024.05.24 01/2024
4	Сургуулийн дотуур байрны хэсэгчилсэн засвар /Өлгий сум/	149.74	149.74	"Энхдормон" ХХК	Оюунсүвд дэлгэрэх ХХК	2024.08.01 №01
5	Маршал Ю.Цэдэнбалын нэрэмжит Музейн барилгын хэсэгчилсэн засвар /Улаангом сум/	514.75	162.05	"Эрдэнэдэглий" ХХК	Барокко хийц ХХК	2024.07.18 №04/2024
6	600-р байрны 8 айлын орон сууцны барилгын гадна фасад дээврийн засварын ажил /Улаангом сум/	184.92	184.92	"Дазлинг лайт таун" ХХК	Барилгын инженерүүд ХХК	2024.09.16 №29
7	Онцгой байдлын газрын ажилчдын 8 айлын орон сууцны барилгын гадна фасад, дээврийн засварын ажил /Улаангом сум/	158.01	158.01	"Цаст дуулгын цамхаг" ХХК	Барилгын инженерүүд ХХК	2024.09.11
8	ЗДТГ-ын байрны засвар, шинэчлэл /Хяргас сум/	78.70	78.70	"Хүрэлбуян" ХХК	Барокко хийц ХХК	2024.11.24 №09/2024
9	Сумын төвийн тохижилт, ногоон байгууламж /Өндөрхангай сум/	49.58	49.58	"Эйбов зеро" ххк	Барокко хийц ХХК	2024.07.22 05/2024
10	Цагдаагийн кабоны засвар, шинэчлэл /Тэс сум/	50.00	50.00	"Мөнхийн Ундраа Увс" ХХК	Гурван тэрмис ххк	2024.07.23 №01
11	ЕБ-ийн цогцолбор 2-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт /Улаангом сум/	245.80	245.80	"Эрхэм импайр" ХХК-ийн	Барокко хийц ХХК	2024.08.30 13/2024
12	Соёлын төвийн засвар /Баруунтуруун сум/	110.00	110.00	"Цаст дуулгын цамхаг" ХХК	Барокко хийц ХХК	2024.12.17 24/2024
13	Гудамжны гэрэлтүүлгийн ажил /Улаангом сум, 4-р баг/	219.88	219.88	"Оточ буян" ХХК	Оюунсүвд дэлгэрэх ХХК	2024.08.02 №01
14	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Улаангом сум, 6-р баг/	130.96	130.96	"Оточ буян" ХХК	Барокко хийц ХХК	2024.05.24 №02
15	Сумын төвийн гэрэлтүүлэг /Давст сум/	63.43	63.43	"Тото лайтинг сервис" ххк	Гурван тэрмис ххк	2024.09.03 №04/24
16	Улаангом сумын 5-р багийн хатуу хучилттай авто зам /Улаангом сум 5-р баг, Эрдмийн эхлэл сургуулийн урд засмал замыг үргэлжлүүлэх/	542.01	542.01	"Дүүрэншим" ХХК	"Засмал зам" ХХК	2024.10.14 №01

17	Аймгийн Цагдаагийн газрын гадна авто зогсоол /Улаангом/	339.30	339.30	"Цагаанхөшөө трейд" ХХК	Гурван тэрмис ххк	2024.08.05 №02/24
----	---	--------	--------	-------------------------	-------------------	-------------------

Эх сурвалж: 2024 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

3.4 Хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээний 425.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан улсын комисс хүлээн авсан, данс бүртгэлд тусгаагүй 425.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Дотуур байрны барилгын засвар, тохижилтын ажил /Тэс сум/-356.9 сая төгрөг,
2. Сумын төвийн тохижилт, ногоон байгууламж /Өндөрхангай сум/-49.6 сая төгрөг,
3. “Ногоон бүс” камержуулалт /Улаангом сум/ багц 2-19.0 сая төгрөг,

Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгуулах зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
2. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 1 гомдол гаргасан байна.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжилтийг олгосон байна.
4. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 452.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.
5. Гэрээ байгуулаагүй “Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр” төсөл, арга хэмжээний 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.
6. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
7. Хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээний 425.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд уялдуулан төлөвлөх.
2. Гэрээ байгуулаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулахгүй байх.

Аймгийн Засаг дарга, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт:

1. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй 2 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх.

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 425.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах.

Нэгтгэл тайланд тусгуулах санал:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан гомдлыг Сангийн яам хянан үзэж захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж, тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн байна. Уг мэдэгдлийн дагуу үнэлгээний хороо дахин хуралдаж сонгон шалгаруулалтын өмнөх шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Үнэлгээний хороо дахин хуралдсан ч шийдвэртээ өөрчлөлт оруулаагүй тохиолдлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүйгээс маргаан үүсч Шүүхийн байгууллагад шилжих, төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна. Иймд Сангийн яаманд гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэх холбоотой ажиллаж байхыг нэгтгэл тайланд тусгаж холбогдох яам, агентлагт уламжлуулах саналыг хүргүүлж байна.

Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn